



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙНЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 24 өдөр

Дугаар 1102


Мандалговь

Түр штаб байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 59.1.21, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын онцгой комиссын дэргэдэх түр штабыг 2023 оны 07 дугаар сарын 24-ний өдрийн 13:00 цагаас 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 18:00 цаг хүртэл байгуулсугай.
2. Түр штабын ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар,
3. Учирсан хохирлын хэмжээг тогтоож, үнэлгээ хийх ажлын хэсгийг 2 дугаар хавсралтаар.
4. Эрүүл ахуй, ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлын хэсгийг 3 дугаар хавсралтаар.
5. Нийтийн эзэмшлийн зам, талбайд учирсан эвдрэл гэмтлийг сэргээн засварлах ажлын хэсгийг 4 дүгээр хавсралтаар.
6. Болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах ажлын хэсгийг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
7. Сумын мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнийг бэлэн байлгахыг тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн), байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.
8. Цаг агаарын мэдээ, мэдээллийг сумын малчид, иргэдэд тогтмол хүргэж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
9. Штабын үйл ажиллагаатай холбоотой гарах зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Тамгын газрын дарга (Ц.Лхагвасүрэн), нягтлан бодогч (Б.Батзориг) нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.БАТ-ОРГИЛ

2823012357